



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/498

Алтай хот

“Алтайн залуус-2022” Дэлгэр сумын
малчин залуучуудын чуулган, арга
хэмжээ зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2, 10.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.7.1 дэх заалт, Удирдлагын зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


1. Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, нийгэм дэх тэдний оролцоог дэмжих зорилгоор “Алтайн залуус-2022” Дэлгэр сумын малчин залуучуудын чуулган, арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 12,13,14-ний өдрүүдэд зохион байгуулж, шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 2,940,000 (хоёр сая есөн зуун дөчин мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

САМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2012 оны 08
дугаар сарын 11-ны өдрийн 41497 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Цайны завсарлага, еглөөний цай-2 удаа Үдийн хоол-2 удаа Оройн хоол-2 удаа	11	68,000	748,000
2.	Дэлгэр-Алтай хот-Дөргөн нуур-Алтай хот-Дэлгэр ирж очих автомашины шатахууны зардал (2 талдаа нийт 776 км)	1 автомашин	492,000	492,000
3.	Жуулчны баазын төлбөр	1 гэр*2 өдөр	100,000	200,000
4.	Аюулгүйн бүс, гортик тогтоох уяа	1000 м	1,500	1,500,000
Нийт зардал				2,940,000

oOo